



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/378

Булган сум

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын даргыг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс”-ын даргаар Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Нарантуяа)-ийг томилсугай.

2.Холбогдох хуулийг баримтлан эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүнийг байгуулж, тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагуудад хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд холбогдох хууль, тогтоомж, тушаалыг баримтлан хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

4.Тус захирамж гарсантай холбогдуулан 2023 оны А/387 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

